



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.02.01. № 01/246
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг үндэслэн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт хуудастай.



Н.УЧРАЛ

1523060984

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2023 оны 02 дугаар сарын 02 -ны өдрийн
01/246 дугаар албан бичгийн хавсралт



СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

Баталгаажуулсан:

Цахим хөгжил харилцаа холбооны сайд

(албан тушаал)

Тэмдэг

(гарын үсэг)

.....
(огноо)

Төсвийн ерөнхийлөгч захирагч

Н.УЧРАЛ

Хүснэгт 3. Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам

Зорилт	Хэрэгжүүлэх арга зам /стратеги /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
Ерөнхий чиг үүрэг: Монгол Улсын цахим хөгжил, харилцаа холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, сансрын технологи, өргөн нэвтрүүлгийн талаарх хууль тогтоомж, бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, Сайд болон Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ.							
Үндсэн чиг үүрэг 1: Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлгийн, радио давтамж, сансрын технологи, кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах судалгаа шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын уялдааг хангах, бодлогын удирдамжаар хангах							
1.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим засаглал, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын холбоо, инновацын бодлогыг төлөвлөх, салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах	1.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх улс хоорондын интернэтийн транзит урсгал дамжуулах бодлогын баримтлах чиглэлийн төсөл боловсруулах	Бодлогын баримтлах чиглэлийн төслийн тоо	0	бодлогын баримтлах чиглэлийн төсөл - 1	-	Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх улс хоорондын интернэтийн транзит урсгалын баримтлах бодлогын чиглэлийг "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2050"-ын төсөлд тусгуулсан.	30%
	1.1.2.Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэхэд бодлогын баримтлах чиглэл боловсруулах	Бодлогын баримтлах чиглэлийн тоо	0	бодлогын баримтлах чиглэлийн төсөл - 1	-	Харилцаа холбооны зохицуулах хороо, ITU, APNIC олон улсын байгууллага хамтран 2018–2020 оны санал асуулгыг үндэслэн бэлэн байдлын судалгаа хийсэн. Судалгааны дүгнэлтийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо, APNIC болон "Систем сэнтер" ТББ-тай хамтран Монгол улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах судалгаа хийж байна.	30%

	1.1.3.Гамшгийн болон онцгой байдлын үеийн холбооны сүлжээний зохион байгуулалтыг төлөвлөх	Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшгаас хамгаалах шинэчлэн боловсруулсан төлөвлөгөөний тоо	0	шинэчлэн боловсруулсан төлөвлөгөө 2	-	Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөх, Онцгой байдлын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо болон харилцаа холбооны сүлжээ эзэмшигч байгууллагуудтай хамтран төлөвлөгөө боловсруулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/01 тушаалаар "Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшиг болон аюулгүй дохио, сэрэмжлүүлгийг дамжуулах журам"-ыг баталсан. Мөн уг ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд 2022 оны "Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө батлах тухай" А/90 дугаар тушаал баталсан.	100%
	1.1.4.Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр журмын төсөл боловсруулах	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Цахим гарын үсгийн тухай хуулийг дагаж гарах журмын төслийн тоо	0	боловсруулсан журмын тоо - 8	-	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, хэрэгжиж эхэлсэн. 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 17 журмыг батлуулсан. Тодруулбал "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам", "Төрийн нээлттэй өгөгдлийн жагсаалт", "Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам", "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам", "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам" зэргийг тус тус батлан хэрэгжүүлж байна.	100%

	<p>1.1.5.Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах</p>	<p>Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн тоо</p>	<p>0</p>	<p>Нэгдсэн бодлого төлөвлөлтийн тоо -1</p>	<p>-</p>	<p>Монгол Улсын цахим шилжилтийг дэмжиж эрчимжүүлэх, төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах ажлын хүрээнд салбарын өнөөгийн байдал, статистик үзүүлэлтийг тодорхойлон, 2022-2027 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг үндсэн 6 зорилгоор тодорхойлж, нийт 123 үйл ажиллагааны чиглэл гаргасан. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд "Цахим үндэстэн" баримтлах чиглэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны А/24 дүгээр тушаалаар баталсан.</p>	<p>100%</p>
	<p>1.1.6.Кибер аюулгүй байдал, нийтийн түлхүүрийн дэд бүтэц, цахим орчинд хүний хувийн мэдээллийг хамгаалах талаарх журмын төсөл, стратеги боловсруулах</p>	<p>Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам, Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө, Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулсан байна.</p>	<p>0</p>	<p>нийтлэг журам 1 төлөвлөгөө 1 үндэсний стратеги 1</p>	<p>-</p>	<p>1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 13 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2022 оны А/115, А/104 дүгээр хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын төслийг боловсруулсан. 2.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/05 дугаар тушаалаар кибер аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Монгол улсын кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг 5 зорилт, 40 үйл ажиллагаатайгаар боловсруулж, Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор баталсан. 3. Дээрх Засгийн газрын тогтоолыг үндэслэн Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 онд батлуулахаар ажиллаж байна.</p>	<p>90%</p>

		Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журам боловсруулсан байна.	0	нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журам 1	-	<p>Цахим гарын үсгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтын заалтын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар "Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журам"-ыг баталсан.</p> <p>Цахим гарын үсгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтын дагуу "Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/81 дүгээр тушаалаар баталсан.</p> <p>Мөн Цахим гарын үсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэгт заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам"-ыг баталсан.</p>	100%
1.1.7.Алслагдсан сум, суурин газарт харилцаа холбооны үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх болон бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлогыг тодорхойлох		Бодлогын баримтлах чиглэлийн тоо	0	бодлогын баримтлах чиглэл - 1	-	<p>Бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлогын баримтлах чиглэлийн төсөл боловсруулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн А/73 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгээс "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлогын баримтлах чиглэл"-ийн төслийг боловсруулсан бөгөөд 2023 онд батлуулахаар байна.</p>	30%

	<p>1.1.8.Өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримтлах бодлого, өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан, өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах, төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулах зэрэг журмын төслүүдийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах</p>	<p>төрөөс баримтлах бодлогын тоо холбогдох журмын төслийн тоо</p>	1	<p>төрөөс баримтлах бодлого - 1 өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сангийн журам - 1 өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам - 1 дамжуулалтын журам - 1</p>	-	<p>1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/29 дугаар тушаалаар "Өргөн нэвтрүүлгийн талаар бодлогын баримтлах чиглэл боловсруулах" ажлын хэсэг байгуулав. 2."Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам"-ыг боловсруулж, Засгийн газрыг хэрэг эрхлэх газарт 12 дугаар сарын 7-ны өдрийн 01/2175 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/01 тушаалаар "Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшиг болон аюулгүй дохио, сэрэмжлүүлгийг дамжуулах журам"-ыг баталсан. 4.Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг боловсруулсан.</p>	70%
	<p>1.1.9.Шуудан, цахим худалдааны чиглэлийн олон улсын, бүсийн, гадаадын болон дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<p>Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	0	<p>зохион байгуулсан арга хэмжээ 3</p>	-	<p>-Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Шуудангийн маркийн улсын фондын хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг, шалгалт хийж, улсын фондод 2021-2022 онд шинээр хэвлэгдэн гарсан шуудангийн маркт баяжуулалт" хийх арга хэмжээ зохион байгуулав. -Азийн хөгжлийн банкттай хамтран "Дижитал эдийн засагт таатай орчныг бүрдүүлэх" техникийн туслалцааны ТА-6618 төслийн хүрээнд Монгол Улс дахь цахим худалдааг үр дүнтэй, үр ашигтай явуулахад учрах хууль эрх зүйн болон зохицуулалтын саад</p>	70%

						бэрхшээлийг тодруулж, сайжруулах зөвлөмж боловсруулах арга хэмжээ зохион байгуулав.	
	1.1.10. Шуудангийн үндсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдал, олон улсын шуудангийн сүлжээний бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох журмын төсөл боловсруулах	Журмын төслийн тоо	0	журмын төслийн тоо 1	-	Шуудангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасны дагуу Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журмын төслийг боловсруулах, шуудангийн үндсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд холбогдох судалгаануудыг хийж, журмын төслийг зарчмын хувьд ялгаатай 2 хувилбараар боловсруулан, батлуулахаар ажиллаж байна.	70%
	1.1.11. Шуудангийн дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах	Хөгжлийн бодлогын төслийн тоо	0	хөгжлийн бодлогын төслийн тоо 1	-	Шуудангийн салбарын өнөөгийн нөхцөл байдал хийгээд Эстони улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын шуудангийн салбарын талаар баримталж буй бодлогод судалгаа хийсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/24 дүгээр тушаалаар Цахим Үндэстэн бодлогын баримтлах чиглэлийн Дэд бүтцийн бэлэн байдлыг хангах зорилтын хүрээнд шуудангийн чиглэлээр хэрэгжүүлэх 13 үйл ажиллагааг тусгасан. Эдийн засгийн хөгжлийн яамнаас боловсруулж буй Хөгжлийн зорилтот хөтөлбөр, "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал-2050"-д шуудангийн чиглэлээрх ажлуудыг тусгуулахаар санал боловсруулж хүргүүлсэн.	30%

	1.1.12. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн инновац, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн судалгаа хөгжил, инновацыг хөгжүүлэх талаар боловсруулсан бодлогын чиглэлийн тоо	0	судалгаа хөгжил, инновацыг хөгжүүлэх талаар бодлогын чиглэл - 1	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/119 дүгээр тушаалаар байгуулсан "Технологи дамжуулах төв болон хамтын оффист бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих тухай" журам боловсруулах ажлын хүрээнд холбогдох судалгааг хийсэн.	30%
	1.1.13. Салбарын судалгаа, шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа, хөгжүүлэлтийн ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх	Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацын кластер байгуулах талаар боловсруулсан төслийн хувилбарын тоо	0	төслийн хувилбар 1	Улсын төсөв	Монгол Улсыг хөгжүүлэх 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд "Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, инновацын кластер байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах" төслийн танилцуулгыг, холбогдох маягтын дагуу боловсруулсан. Буянт-Ухаа нисэх буудлын байрны тодорхой хэсгийг түшиглэн, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн үйл ажиллагааг өргөжүүлж, Монголын цахиурын хөндий, мэдээлэл технологийн чөлөөт бүсийг бий болгох зорилготой "Буянт-Ухаа инновацын төв"-ийг байгуулах талаар холбогдох судалгааг хийж, ЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Мэдээлэл, холбооны өндөр технологийг хөгжүүлэх, инновацын чиглэлээр хамтран ажиллах зорилгоор олон улсын томоохон байгууллагуудтай хамтран ажиллах талаар судалж, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлон эдгээр байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг хүсэх талаар Гадаад харилцааны яаманд 2022 оны 03/2089 дугаар албан бичгээр хүсэлт илгээгээд байна.	0%

		Мэдээллийн технологийн аж үйлдвэрийн парк байгуулах талаар боловсруулсан төслийн хувилбарын тоо	0	төслийн хувилбар 1	Улсын төсөв	"Буянт-Ухаа инновацын төв" байгуулах тухай танилцуулга бэлтгэн 2022 оны 09 сарын 14-ний өдөр Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны тэмдэглэл гаргасан.	
	1.1.14.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бодлогын чиглэл боловсруулах	Боловсруулсан бодлогын чиглэлийн тоо	0	бодлогын чиглэл 1	-	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжүүлэх, эрэлт хэрэгцээг Төрийн захиргааны байгууллагад харилцаа холбоо мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж байгаа хүний нөөцийн судалгаанд нийт 92 байгууллага хамрагдсан. Судалгааны өгөгдөлд боловсруулалт хийж, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дугаар тушаалаар "Цахим үндэстэн" бодлогын баримтлах чиглэлийг баталсан. Уг бодлогын баримт бичгийн 6 зорилтын хүрээнд салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар тусгасан.	100%
	1.1.15. Тоон контентын хөгжлийг дэмжих бодлогын баримтлах чиглэлийг боловсруулах, үндэсний тоон контент үйлдвэрлэлийн төв байгуулах төслийн хувилбарыг боловсруулах	Бодлогын баримтлах чиглэлийн тоо, төслийн хувилбарын тоо	0	бодлогын баримтлах чиглэл-1 төслийн хувилбар-1	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж, Хамтын ажиллагаа	1.Тоон контентын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн хэдий ч соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүргийн яам болох Соёлын яамтай хамтран ажиллах чиглэл гарсан. Иймд хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамнаас орж ажиллаж, тоон контент үйлдвэрлэлийн нөхцөл байдлын дүн шинжилгээний судалгаа, баримтлах чиглэлийн төслийг Соёлын яаманд хүргүүлсэн. Үндэсний тоон контент үйлдвэрлэлийн жишиг төв байгуулах ТЭЗҮ-ийн саналыг боловсруулан Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн Яам, Барилга, хот байгуулалтын яаманд тус тус хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтад суугаагүй тул Олон Улсын байгууллагуудад төслийн баримт бичгийг боловсруулан хүргүүлснээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний	90%

						мэдээлэлжсэн нийгмийн агентлаг хамтран ажиллахаар хүсэлт ирүүлсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний паркийн байранд 360м2 талбайг тохижуулах Цахим ур чадварыг дээшлүүлэх болон Контент үйлдвэрлэлийн жишиг төвийг байгуулж 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлэв.	
1.2.Цахим хөгжил, харилцаа холбоо, мэдээллийн технологийн судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, салбарын статистик мэдээллийг боловсронгуй болгох	1.2.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн бодлого, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн судалгаа, шинжилгээг хийх	Бодлогын болон төсөл, хөтөлбөрийн судалгаа, шинжилгээ хийгдсэн байна.	4	10	-	Дэлхийн банкнаас хоёр жил тутамд гаргадаг Төрийн байгууллагуудын технологийн хэрэглээний чадавхын индекс /GovTech Maturity Index/-ийг гаргах зорилгоор төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг судалгаанд нэгтгэж Дэлхийн банканд хүргүүлсэн. Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж буй цахим засаглалын G2G, G2B, G2C чиглэлийн мэдээллийн систем, платформууд, цахим засаглалын чиглэлийн шинэлэг шийдэл, санаачилгууд зэрэг суурь судалгааг хийж гүйцэтгэсэн.	30%
	1.2.2.Салбарын статистик мэдээ мэдээллийг боловсруулах, нэгтгэх, жил бүрийн нэгтгэлийг цаасан болон цахим хэлбэрээр гаргах	Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	0	Салбарын статистик мэдээллийн сан 1	-	Сүүлд 2019 онд хэвлэгдсэн салбарын нэгдсэн мэдээллийн “Цагаан ном”-ны товъёгийг дахин боловсруулж, бүх газруудад бичгээр өгч санал авсан, эдгээрээс 3 төрлийн үзүүлэлтийн шинэчлэн бэлтгэж, цагаан номыг эхийг бэлтгэж байна.	30%
	1.2.3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индекс, үзүүлэлтүүдийн судалгааны сан бүрдүүлэх, судалгаа гаргах	Салбарын судалгаа, шинжилгээний сан бүрдүүлэх	0	Салбарын судалгаа, шинжилгээний мэдээллийн сан 1	-	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, Өрхийн судалгаа, Цахим засаглалын бэлэн байдлыг үнэлэх судалгаа, IPv6 бэлэн байдлын судалгаа, Монгол улсын стартап экосистемийн суурь судалгаа зэрэг судалгаануудаар судалгааны санг баяжуулсан.	70%
Үндсэн чиг үүрэг 2: Мэдээллийн технологи, цахим засаглал болон нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах							

2.1.Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах	2.1.1.Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний бодлого, журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах	Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр журмын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангасан байна.	0	1	Улсын төсөв	1. Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Нийтийн мэдээллийн дэд бүтэц, түүний үйл ажиллагааг зохицуулсан нийт 14 захиргааны актыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, батлуулсан. 2.Батлагдсан актын хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 232 болон 200 дугаар тогтоолын дагуу нийт 54 байгууллагын 554 нээлттэй өгөгдлийг байршуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоол дагуу 18 байгууллагыг өөрийн цахим хуудсандаа нээлттэй байлгах аар заасан мэдээллийг цаг тухайд нь байршуулж, шинэчилж байгаа эсэхэд үнэлгээ хийсэн. Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хүрээнд Үндсэн систем "ХУР"-тай холбогдох 145 байгууллага, Танилт, нэвтрэлтийн систем "ДАН"-тай 74 байгууллага, Мэдэгдэл хүргэх системтэй 1, Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй 1 байгууллагатай тус тус гэрээ байгуулсан. Сайдын 2022 оны А/18 дугаар тушаалаар баталсан "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ын хүрээнд нийт 13 байгууллагад зөвлөмж, дүгнэлт боловсруулан хүргүүлсэн.	100%
		Аймаг, орон нутгийн үйлчилгээнүүдийг И-Монгол нэгдсэн системд нэгтгэсэн байна.	250	750	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" платформд 21 аймгийн 1234 үйлчилгээг нэгтгэсэн.	100%
	2.1.2.Нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ,	Мэдээллийн технологиор дэмжих салбарын тоо	0	15	Улсын төсөв	Дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Үндэсний программ хангамжийн их дэлгүүр "Mindgolia.mn", lavlagaa.e-Mongolia.mn, Албан бичиг солилцооны "DocX" дундын системүүдийг хэрэглээнд нэвтрүүлсэн.	100%

	хэрэглээг бий болгох хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах				<p>-Төрийн 193 байгууллагын цахим шууданг "Үндэсний цахим шуудангийн систем"-д холбосон.</p> <p>- Барилга, хот байгуулалтын яамтай газар, үл хөдлөх хөрөнгийн хаягжилтыг сайжруулах, Эрүүл мэндийн яамтай "Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах" журмын төслийг боловсруулах, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай "Аялал жуулчлалын нэгдсэн платформ"-ыг хөгжүүлэх, Зам, тээвэр хөгжлийн яамтай авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээний загвар боловсруулах, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаа"-ны журам, Боловсрол, шинжлэх ухааны яамтай "Дээд боловсролын мэдээллийн систем хооронд харилцан мэдээлэл солилцох, Хууль зүй, дотоод хэргийн яамтай "Хилийн мэдээллийн нэгдсэн төв" байгуулах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай 2018, 2020 онуудад хамрагдсан нийт 150,000 гаруй иргэний мэдээллийг төрийн 13 байгууллагын мэдээллийн сантай тулгах, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах төлөвлөгөө, Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох, "Хилийн нэгдсэн мэдээллийн систем болон дата санг хөгжүүлж, нэвтрүүлэх" зэрэг төсөл, арга хэмжээг хамтран зохион байгуулж, санал, зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан.</p> <p>Мөн "Цахим аймаг" төслийн хүрээнд аймаг, нийслэлийн ЗДТГ-аас ирүүлсэн мэдээллийн системүүдийн шинэчлэл, өөрчлөлтөд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>
--	---	--	--	--	--

		Төрийн үйлчилгээний И-Монгол нэгдсэн системд нэгтгэж цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний тоо	606	1000	Улсын төсөв	И-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн системд 71 байгууллагын 806, орон нутгийн 1285 үйлчилгээг нэгтгэсэн. Мөн 10 тодорхойлолтыг англи хэл дээр гаргадаг болсон. 2022 онд 383,750 хэрэглэгч шинээр бүртгэгдсэн.	100%
		И-Монгол системээр үйлчилгээ авсан тоо	6,8 сая	8 сая	-	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" платформыг ашиглан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд төрийн цахим үйлчилгээг нийслэл, орон нутагт байрлах төрийн үйлчилгээний нэгдсэн төв, "E-Mongolia" цахим сайт болон гар утасны "E-Mongolia" аппликейнаар авах боломж бүрдсэн. Одоогийн байдлаар иргэд давхардсан тоогоор нийт 19,715,313 үйлчилгээг цахимаар авсан байна.	100%
	2.1.3.Шинжлэх ухааны байгууллага, судалгаа шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, зохицуулах	Салбарын судалгаа шинжилгээ, лабораториудыг нэгтгэсэн мэдээллийн технологийн кластер төв байгуулахад дэмжлэг үзүүлэх	0	1	Улсын төсөв	1.Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 59 дүгээр тушаалаар байгуулагдсан "Залуус"-1 цогцолбор хороолол барихад шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх хувилбарыг судлах ажлын хэсгийн хүрээнд уг хорооллыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын кластер хэлбэрээр хөгжүүлэхээр төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Залуус-1 хороололд харилцаа холбооны суурь сүлжээ, дэд бүтцийг бий болгохоор 4, 6 яндантай худаг сувагчлал байгуулах төсөл боловсруулж, холбогдох тооцоо судалгааг гаргасан. 2.Буянт-Ухаа нисэх буудлын байрны тодорхой хэсгийг түшиглэн, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн үйл ажиллагааг өргөжүүлж, Монголын цахиурын хөндий, мэдээлэл технологийн чөлөөт бүс бий болгох зорилготой "Буянт-Ухаа инновацын төв"-ийг байгуулах саналыг боловсруулж, Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд тусгуулсан.	30%

2.2.Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх	2.2.1.Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д холбогдсон байгууллагын тоо	278	400	Улсын төсөв	Төрийн мэдээлэл солилцооны систем "ХУР"-д төрийн 110, хувийн хэвшлийн 277 байгууллага нийт 387 байгууллага тус тус холбогдож, 566 сервисийг нийт 1,300,520,38 /1,109,010,100/ удаа дамжуулсан.	100%
		Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д шинээр хөгжүүлсэн сервисийн тоо	436	600	Улсын төсөв	Төрийн мэдээлэл солилцооны систем "ХУР"-д шинээр хөгжүүлсэн сервисийн тоо 130 буюу нийт 566 сервис байна.	100%
		Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН) -д холбогдсон системийн тоо	102	132	Улсын төсөв	Танилт, нэвтрэлтийн "ДАН"системд төрийн 48 байгууллагын 95 систем, хувийн хэвшлийн 119 байгууллагын 134 систем холбогдсон.	100%
		Албан бичгийн солилцооны дундын системд холбогдсон системийн тоо	3	6	Улсын төсөв	Албан бичиг солилцооны дундын систем (DocX)-ийг Аблесофт, ер.e-mongolia.mn, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын системд холбосон бөгөөд Төрийн болон хувийн хэвшлийн нийт 15+ ер системийг албан бичиг солилцооны дундын системд холбон, 5483 байгууллага бүртгэж, одоогийн байдлаар байгууллага хооронд 553,032 (Ирсэн бичиг+Явсан бичиг) албан бичгийг цахим хэлбэрээр солилцсон ба 7987 албан бичгийн 8742 хавсралт файлыг солилцсон байна.	100%
2.3.Цахим засаглалыг хөгжүүлэх	2.3.1.Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	Мэдээллийн сангийн нэгдсэн ангилалд бүртгүүлсэн өгөгдлийн тоо	0	200	Улсын төсөв	1.Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулж, мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэл хөтлөхөд ашиглагдах Статистикийн үйл ажиллагаанд хамаарах нийтийн мэдээллийн сангийн "Нэгдсэн ангилал кодын тайлбар"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны А/79, А/193 дугаар тушаалаар батлуулсан. 2.Төрийн их өгөгдлийн сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох	70%

						<p>зорилгоор үндэсний өгөгдлийн талаар баримтлах чиглэл боловсруулах, нийтийн мэдээллийн сангийн мета өгөгдлийн системийг үүсгэх шийдэл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2022 оны А/84, А/209 дугаар тушаалаар байгуулж, дараах ажлыг хийж байна. Үүнд:</p> <p>-Монгол Улс дахь их өгөгдлийн суурь нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох;</p> <p>-Олон улсад хэрэгжүүлж буй дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, өгөгдлийн нийцтэй байдал, өгөгдлийн урсгалын зургийг гаргах;</p>	
		Нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд бүртгүүлсэн нээлттэй өгөгдлийн бүрдлийн тоо	191	400	Улсын төсөв	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоол "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоол "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын хүрээнд нийт 59 байгууллагын 606 нээлттэй өгөгдлийг opendata.gov.mn-д байрлуулахаар төлөвлөсөн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 57 байгууллагын 560 нээлттэй өгөгдлийг байршуулаад байна.</p>	
Үндсэн чиг үүрэг 3: Харилцаа холбооны хөгжлийн бодлого, стандартыг хэрэгжүүлэх, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, нөөц сүлжээ байгуулах төсөл, хөтөлбөрийг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
3.1.Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах	3.1.1.Харилцаа холбооны сүлжээ өргөтгөх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хууль, тогтоомж, хөгжлийн бодлого, дүрэм, журам, аргачлал, стандартын хэрэгжилтийг хангах	Харилцаа холбооны чиглэлийн хууль, тогтоомж, хөгжлийн бодлого, дүрэм, журам, аргачлал, стандартын хэрэгжилтийг хангасан байна.	20	23	-	Бүх нийтийн үүргийн үйлчилгээний санг бүрдүүлэх, зарцуулах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан. Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн хөрөнгөөр 2022 онд нийт 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	70%

		Мэдээлэл, харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг байгуулах, өргөтгөх, шинэчлэх ажлыг зам, тээвэр, хот байгуулалт, эрчим хүчний дэд бүтцийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай уялдуулах, төсөл хөтөлбөрийн уялдаа холбоог хангасан байна.	0	2		Барилгын хөгжлийн төвийн дэргэдэх Инженерийн байгууламж, шугам сүлжээний инженерийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар Барилгын хөгжлийн төвийн захиалгаар "Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зураг төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм"-ийг шинээр боловсруулах ажлыг "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК болон Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн хамтарсан баг гүйцэтгэн танилцуулсан.	30%
		Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх бодлогын баримтлах чиглэл боловсруулахад дэмжлэг үзүүлсэн байна.	0	1	-	IPv6 шилжих хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор "дотоод сүлжээ хуваарилалт" "сүлжээний аюулгүй байдал домэйн нэрийн серверийн хангамж" 2 удаагийн сургалт зохион байгуулж интернэт хяналтын өмчийн судалгаа хийсэн. 2023 онд IPv6-руу шилжих нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж байна.	30%
		Хөдөлгөөнт холбооны 5 дах үеийн технологийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн байна.	1 бодлогын баримтлах чиглэл батлагдсан.	Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээг нэвтрүүлж эхэлсэн байна.	-	Бодлогын чиглэлийн 4.6 дахь хэсэгт заасны дагуу Үүрэн холбооны оператор компаниуд Улаанбаатар хотод 5G сүлжээний станцуудыг байгуулан 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдөр хүртэл туршилт хийх зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос авч 5G сүлжээг ажиллуулж байна.	100%

		Гамшгийн урьдчилан сэргийлэх мэдээг дамжуулах болон гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	0	2	-	Гамшгийн урьдчилан сэргийлэх мэдээг дамжуулах болон гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газар, Нэгдсэн Үндэсний байгууллагын хүүхдийн сантай хамтран 2022 оны 4 сард Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны команд штабын бүрэлдэхүүн байгууллагуудыг хамруулан "Газар хөдлөлтийн гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлын" сургалт, дадлагыг зохион байгуулсан. Энэхүү сургалт, дадлагаас гарсан үр дүнд суурилан Гамшгийн урьдчилан сэргийлэх мэдээг дамжуулах болон гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд хэрэгжилтийг зохион байгуулж байна.	70%
		Бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлогын баримтлах чиглэл боловсруулахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангасан байна.	0	1	-	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн тул Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн бодлогын баримт бичгийг батлуулах шаардлагагүй болсон.	100%
3.1.2.Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, нөөц сүлжээ байгуулах арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих	Алслагдсан сум, суурин газар, А зэрэглэлийн зам дагуу, аялал жуулчлалын бүс нутгийг шилэн кабелийн сүлжээнд холбож харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг	325 сум, 11 боомт шилэн кабелийн сүлжээнд холбогдсон.	5 сум, 5 боомт	Улсын төсөв	Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд алслагдсан 5 сум, 5 боомтыг шилэн кабелийн сүлжээнд холбох төслийн санал хүргүүлсэн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй. 2021-2022 онд "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ний хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн Алтай сум, Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багаас Халхгол сумын төв хүртэл 60км шилэн кабель сүлжээ байгуулсан. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2022 оны хөрөнгө оруулалтаар Өвөрхангай	70%	

		нэмэгдүүлсэн байна.				аймгийн Уянга сумын Жаргалант багт 60км урт шилэн кабелийн сүлжээ байгуулсан.	
		Аймгуудад байгуулсан өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулсан байна.	0	5 зангилаа төв	Улсын төсөв	Дархан-Уул аймагт 1 зангилаа төв байгуулах ажлын хүрээнд 2022 онд батлагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн дэд төвийн гадна цахилгаан, гадна холбооны ажлыг хийж дуусгасан.	30%
		Шилэн кабелийн сүлжээний багтаамжийг нэмэгдүүлсэн байна.	Сум суурин газрын багтаамж 155-1000 Мбит/сек хооронд байна.	Сум суурин газрын багтаамжийг 5-10 дахин нэмэгдүүлсэн байна.	Улсын төсөв	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын 80 сумдад дамжуулах сүлжээ болон өгөгдлийн сүлжээний тоног төхөөрөмжийн багтаамжийг 10Гбит/с буюу 10 дахин нэмэгдүүлэн өргөтгөсөн. 2022 онд уг ажлыг хийхээр улсын төсөвт санал тусган хүргүүлсэн боловч батлагдаагүй болно.	100%
		Алслагдсан дүүрэг, гэр хорооллын өрхийн харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	0	Алслагдсан хороо 3	Улсын төсөв	Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн хөрөнгө оруулалтаар "Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээ хүргэх" төслийг хүрээнд амьжиргааны түвшин доогуур 5500 өрхөд өндөр хурдны өргөн зурвасын интернэт үйлчилгээ хүргэсэн.	100%
		Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, холбогдох мэдээ мэдээллээр хангаж тайлагнасан байна.	0	Шинээр сүлжээ оруулах цэг 26, шилэн кабелийн сүлжээнд холбох цэг 3, сүлжээний өргөтгөл хийх цэг 9, цамхаг барих цэг 3	БНҮҮС	"Хөдөө орон нутгийн алслагдсан сумын багт хөдөлгөөнт холбооны сүлжээний өргөтгөл" төсөл, "Өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбох" төсөл, "Гэр хорооллын бүсэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээ хүргэх" төсөл, "Шуудангийн хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх" төслүүдийг хэрэгжүүлж дууссан. Эдгээр ажлын хүрээнд нийт 37 байршилд сүлжээний өргөтгөл болон шинээр сүлжээ оруулж 1 цэгт шилэн кабелийн угсралт хийсэн байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2022 оны хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багт 60км урт шилэн кабелийн сүлжээ байгуулсан.	70%

3.2.Сансрын холбооны бодлогын хэрэгжилтийг хангах	3.2.1.Үндэсний радио давтамжийн төлөвлөлтийн газрын сүлжээ болон сансрын сүлжээний радио давтамжийн нөөцийг ашиглах, хуваарилах ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулах	Үндэсний радио давтамжийн нөөцийн төлөвлөлтийг шинэчлэн боловсруулсан байна.	1	1	Улсын төсөв	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/29 дугаар тушаалаар "Дэлхийн радио холбооны их хурал (WRC23), түүний бэлтгэл хурлуудад оруулах Монгол Улсын саналыг нэгтгэн боловсруулах" үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг хиймэл дагуулын үйлчилгээний асуудлаар /APG23-4-д Хэлэлцэх асуудал 7 (WP4)-д/, газрын хөдөлгөөнт холбооны асуудлаар /Хэлэлцэх асуудал 1.2 (WP1)-д Монгол Улсын саналыг нэгтгэн боловсруулж, бүсийн хурлуудад танилцуулсан.	30%
		Үндэсний радио давтамжийн хуваарилалт, ашиглалтын талаар бодлогын удирдамжаар хангасан байна.	0	2	Улсын төсөв	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох аргачлалыг боловсруулж "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам"-ыг шинэчлэн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/37 дугаар тушаалаар баталсан. ОУЦХБ-аас "Монгол Улсад 5G технологийг нэвтрүүлэхэд зах зээлийн бэлэн байдлыг тодорхойлох" зөвлөх үйлчилгээ авсан.	100%
	3.2.2.Хил залгаа улстай радио долгионы асуудлыг зохицуулах	Хил орчмын бүс нутаг дахь радио давтамжийн зохицуулалтын орчин хангагдах нөхцөл бүрдсэн байна.	1	1	-	Хил залгаа улстай радио долгионы асуудлыг зохицуулах асуудлаар: 1.Оросын Холбооны Улстай 1983, 2013, 2018 онуудад хэлэлцээр хийж, тодорхой давтамжууд дээр гэрээ хийж, гэрээний дагуу хамтран ажиллаж байна. 2.Бүгд Найрамдах Хятад ард улстай 2015, 2017, 2019 онуудад хэлэлцээр хийсэн. 2019 онд 1 давтамж дээр анх гэрээг байгуулсан. 2021 онд хэлэлцээр хийх хуваарьтай байсан хэдий ч цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй.	30%
		Хил орчмын бүс нутаг дахь радио давтамжийн зохицуулалтын гэрээний дагуу хил залгаа улсын	0	1	-	Хил орчмын бүс нутаг дахь радио давтамжийн зохицуулалтын гэрээний дагуу Оросын Холбооны Улсын Радио давтамжийн төвөөс ирүүлсэн VHF/FM радио өргөн нэвтрүүлгийн газрын станцын 11, хиймэл дагуулын хөдөлгөөнт бүс	100%

		холбогдох яам, газруудтай хамтран ажилласан байна.				үйлчилгээний газрын станцын 1, радио давтамжийн харилцан нөлөөлөл үүсгэсэн тухай 1, хиймэл дагуулын газрын станцын 1 нийт 14 хүсэлтэд холбогдох хэмжилт, тооцооллыг хийж, холбогдох хариу албан бичгийг Оросын Холбооны Улсын талд тухай бүр хүргүүлсэн Казакстан улсын Цахилгаан холбооны хорооноос ирүүлсэн нийт 6 газрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээний станцын радио давтамжийн координацийн хүсэлтэд Харилцаа холбооны зохицуулах хороогоор холбогдох хэмжилт, тооцооллыг хийлгэж, хариуг албан бичгээр хүргүүлсэн. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас Дэлхийн радио холбооны дүрмийн 9.17 заалтыг зөрчиж радио давтамжийн харилцан нөлөөлөл үүсгэж байгаа талаарх 2 албан бичигт Харилцаа холбооны зохицуулах хороогоор хууль бус станцын үйл ажиллагааг илрүүлэх хэмжилт, тооцоолол хийлгэж, Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага болон БНХАУ-ын талд албан бичгээр хүргүүлсэн.	
3.2.3. Сансрын технологи, сансрын холбооны хиймэл дагуулын үйлчилгээг нэвтрүүлж, газар, сансар хосолсон өргөн зурвасын сүлжээг бий болгох, үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	Монгол Улсад хуваарилагдсан сансрын холбооны хиймэл дагуулын радио давтамжийн хуваарилалт, орбитын байрлалыг хамгаалсан байна.		0	1	Улсын төсөв	Монгол Улсад хуваарилагдсан сансрын холбооны хиймэл дагуулын радио давтамжийн хуваарилалт, орбитын байрлалыг хамгаалах ажлыг тогтмол хийж байна. Дэлхийн радио холбооны дүрмийн дагуу хөөргөсөн болон хөөргөхөөр төлөвлөж буй хиймэл дагуулын радио давтамжийн координацийн талаарх албан хүсэлтийн хүрээнд Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага болон Люксембург, Турк Улс, Индонез Улсын холбогдох яамдаас нийт 29 албан бичиг ирүүлснийг тухай бүр судалж, холбогдох тооцооллыг хийж хариуг хүргүүлж ажилласан.	100%

		Төрөөс сансар судлалын талаар баримтлах бодлогын чиглэл боловсруулж, батлуулсан байна.	0	1	-	Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/93 дугаар тушаалаар баталсан.	100%
		Монгол Улсад хиймэл дагуулын сүлжээгээр харилцаа холбооны үйлчилгээ нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл боловсруулж, батлуулсан байна.	0	1	-	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/16 дугаар тушаалаар "Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглахад баримтлах бодлогын чиглэл"-ийг баталсан.	100%
	3.2.4.Тандан судалгааны хиймэл дагуулын мэдээг үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх	Тандан судалгааны хиймэл дагуулын зах зээл, хэрэглээний талаарх судалгаа хийсэн байна.	0	1	Улсын төсөв	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/23 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, зайнаас тандан судалгааны хиймэл дагуулын зах зээл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг хийсэн. Шинжлэх ухааны академитай хамтран "Зайнаас тандан судлалын Азийн 43-дугаар их хурлыг 2022 оны 10 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулсан. Уг хуралд 18 орны 500 гаруй судлаачид хамрагдсан.	100%
		Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллаж төсөл хэрэгжүүлсэн байна.	0	1	-	Төсөл хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллахаар нийт 13 удаагийн хурал, сургалтад 34 оролцогчийг хамруулсан. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага, Монгол Улсын Их сургууль хооронд Монголын байгалийн гамшигт үзэгдэл буюу ой, хээрийн түймрийн мониторинг болон түүний эрсдэлийн үнэлгээг зайнаас тандан судлалаар тодорхойлох судалгаа хийхээр хамтран ажиллах гэрээ байгуулж, эхний судалгааг түймэр гарсан бүс нутагт буюу Хэнтий аймагт очиж хийсэн.	100%

						Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар БНХАУ-ын цаг уурын "FY-2" хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах газрын станцын лаборатори байгуулах төслийг Монгол Улсын Их Сургуульд хэрэгжүүлсэн. 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын удирдлагуудын 15 дугаар хуралд оролцож, удирдах зөвлөлийн 16 хурлаар хэлэлцэгдэх баримт бичгүүдэд санал тусгасан.	
3.3. Шуудан, өргөн нэвтрүүлгийн бодлогын хэрэгжилтийг хангах	3.3.1. Радио өргөн нэвтрүүлгийн системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах	Өргөн нэвтрүүлгийн хууль, бодлого, журмын хэрэгжилтийг хангасан байна.	1	3	Улсын төсөв	Өргөн нэвтрүүлгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-д заасан журмын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/74 дүгээр тушаалаар байгуулсан. Тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасан "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам" болон "Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага"-д нэмэлт өөрчлөлт оруулах төслүүдэд санал боловсруулан Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлсэн. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд Хонхорын радио станцыг тоон технологид шилжүүлэх төслийн санал хүргүүлсэн боловч санхүүжилт шийдэгдээгүй. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ний А/76 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд Тоон радиогийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулсан.	30%
		Тоон радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах сүлжээ байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ авсан байна.	0	1	Улсын төсөв		
		Телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	0	1	Улсын төсөв		

	<p>3.3.2. Шуудан, цахим худалдаа, логистикийн салбарт гарч байгаа шинэ техник, технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, шуудангийн үндсэн сүлжээг төрийн дэмжлэгтэйгээр хувийн хэвшилд тулгуурлан өргөтгөн хөгжүүлэх, хөтөлбөр, төслийг боловсруулж, хэрэгжүүлэх, шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх</p>	<p>Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв баригдсан байна.</p>	0	1	Хувийн хэвшил	<p>Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төвийн барилгын гүйцэтгэл 2022 оны жилийн эцсийн байдлаар барилгын дуусаж, 2023 оны хаврын улиралд "Монгол Шуудан" ХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилгын доторх тоног төхөөрөмж, тавилгын тендер худалдан авахаар нийтэд зарласан.</p>	90%
		<p>Шуудангийн нэгдсэн кодыг иргэд, хуулийн этгээдэд таниулах арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	0	4	-	<p>Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас, нийгмийн мэдээллийн сүлжээнд "Шуудангийн нэгдсэн код"-ын танилцуулга видео, мэдээг байршуулан түгээсэн. Монгол Улсын засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр "Газар, үл хөдлөх хөрөнгийн хаягжилт-Орон зайн өгөгдлийн дэд бүтэц"-ийн асуудлаар Цахим хөгжил харилцаа холбооны яам, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газартай хамтран төрийн болон хувийн хэвшлийн 30-н байгууллагатай хаягжилтын асуудлыг шийдвэрлэх нэгдсэн системтэй болох зорилгоор арга хэмжээ зохион байгуулав. Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны 227/А/76 дугаар тушаалаар байгуулагдсан. Тус Ажлын хэсэг нь шуудангийн нэгдсэн кодыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай тулгах, нэгтгэх ажил хийж байна.</p>	
	<p>3.3.3. Үндэсний тоон контент үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх</p>	<p>Үндэсний тоон контент үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.</p>	0	1	Улсын төсөв	<p>Бүгд Найрамдах Солонгос Улстай хамтран Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбоо технологийн хамтын ажиллагааг дэмжих, хүртээмж, ур чадварыг сайжруулах зорилгоор "Цахим ур чадвар олгох төв"-ийг байгуулсан. Цахим ур чадвар олгох төв нь хурлын өрөө, интернэт өрөө, тус бүр 16 иж бүрэн компьютер бусад тоног төхөөрөмжийн бүрдэл бүхий мэдээлэл, харилцаа холбооны технологийн сургалтын 2 танхим, тоон контент бүтээх, контент бүтээгчдийг дэмжин</p>	100%

						хөгжүүлэх 2 танхим, захиргааны албан ерөөнөөс бүрдэх нийт 360м2 талбай бүхий цогц байгууламж юм.	
Үндсэн чиг үүрэг 4: Кибер аюулгүй байдал, хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах							
4.1.Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах	4.1.1.Кибер аюулгүй байдал, хүний хувийн мэдээллийг хамгаалах талаарх бодлого, дүрэм, журам, стратегийн хэрэгжилтийг хангуулах, аргачлал, жагсаалтыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Кибер аюулгүй байдлын дүрэм, журам, стратегийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.	0	1	-	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 13 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавих шаардлага, анхааруулгад тусгах мэдээллийн журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэх ажлыг зохион байгуулж байна. Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги"-г батласан.	100%
		Кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой аргачлал, жагсаалт боловсруулсан байна.	0	5	-	1.Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, аудит хийх журмын төслийг боловсруулсан. Улмаар журмын төслийг боловсронгуй болгохоор санал авч, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Үүнд 16 байгууллагын 19 төлөөлөгч оролцож, санал ирүүлснийг тусгаж журмын төслийг эцэслэн боловсруулсан. 2.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тагнуулын Ерөнхий газрын дарга нарын 2022 оны А/115, А/104 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын төслийг боловсруулсан. 3.Кибер аюулгүй байдал алдагдсанаар хэвийн үйл ажиллагаа нь доголдож Монгол улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болох мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй	

						<p>төрийн болон хувийн хэвшлийн 216 байгууллагын жагсаалтыг гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлснээр Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 207 дугаар тогтоолоор онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтыг баталсан.</p> <p>4.Монгол Улсын Ерөнхий сайдын 13 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журмын төсөл болон аудит хийх аргачлалын төслийг шинэчлэн боловсруулсан.</p> <p>5.Харилцаа холбоо мэдээллийн технологийн аудит хийлгэх төрийн байгууллагын жагсаалтыг Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор баталсан "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт", Засгийн газрын 2022 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалт"-тай уялдуулан 153 байгууллагын жагсаалтыг гаргасан.</p>	
		Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангах, нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулсан байна.	0	1		"Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага"-ын төслийг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 11-нд төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн. "ETSI TS 102 023 Policy requirements for time-stamping authorities" олон улсын стандартад нийцүүлэн төслийг боловсронгуй болгож байна.	
4.1.2.Кибер халдлага, зерчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадварыг бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаатай төвүүдийн	Кибер халдлага зерчилтэй тэмцэх нийтийн төв байгуулагдсан байна.	0	1	-	"Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд Нийтийн төвийг байгуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох хуулийн төсөлд тусгасан. Монгол Улсын Засгийн газраас дээрх саналыг дэмжсэн бөгөөд "Ухаалаг засаг-2" төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай	90%	

хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах					хуулийн төслийг 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын их хуралд өргөн мэдүүлсэн.		
	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна.		0	1	-	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм, зөвлөлийн Ажлын албаны ажиллах журмын төсөл, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүний төслийг холбогдох Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамтаар боловсруулж, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад тусгуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 01/127 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар батлуулсан.	
4.1.3. Кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцооны тогтолцоог бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах	Халдлага зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.		0	1	-	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв байгуулагдсаны дараа кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	0%
4.1.4. Кибер аюулгүй байдлын чиглэлээр дотоод, гадаадын болон олон улсын байгууллагатай хамтарч ажиллах	Хамтран ажиллах олон улсын болон дотоодын байгууллагатай хамтран ажилласан байна.		0	5	-	1. Америкийн нэгдсэн улсын Төрийн Департамент болон тус улсын "MITRE" байгууллагатай хийсэн хамтын ажиллагааны хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 7-9-ний өдрүүдэд "Үндэсний кибер аюулгүй байдлын боловсон хүчний хөгжил" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдтай уулзалт хийж 2 тал цаашид кибер аюулгүй байдлын судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцсон. 2. Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх, иргэд олон нийтийн кибер аюулгүй байдлын	70%

						мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд одоогоор сургалтад 18 багш, албан хаагчийг хамруулаад байна. 3.Бүгд Найрамдах Израил Улстай Кибер аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр байгуулаад байна.	
4.1.5.Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавих	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэлийг хөтөлсөн байна.	0	хөтөлсөн бүртгэл - 1	-	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, аудит хийх журам батлагдаагүйн улмаас мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийн бүртгэл хийгдэж эхлээгүй.	0%	
	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдийн бүртгэлийг хийсэн байна.	0	хуулийн этгээдийн бүртгэл - 1	-	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам батлагдаагүйн улмаас кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдийн бүртгэл хийгдээгүй байна.		
4.1.6.Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ технологи, инновац судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг нэмэгдүүлэх	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийгдсэн байна.	0	2	-	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлэхээр Кибер аюулгүй байдлын үндэсний стратегид тусгасан.	0%	
4.1.7.Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, олон нийтэд мэдлэг олгох арга хэмжээг зохион байгуулах	Мэргэшсэн хүний нөөцийн тоо	0	100	-	1.Америкийн Нэгдсэн Улсын Карнеги Меллоны Их Сургуультай хамтын ажиллагааны хүрээнд Кибер аюулгүй байдлын боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг(CSIRT) байгуулах” сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтад төрийн болон хувийн хэвшлийн нийт 20 байгууллагын 34 албан хаагч хамрагдсан.	90	

						<p>2. Америкийн нэгдсэн улсын Төрийн Департамент болон тус улсын MITRE байгууллагатай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд "Үндэсний кибер аюулгүй байдлын боловсон хүчний хөгжил" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад төрийн байгууллагаас 20 албан хаагч, хувийн хэвшлийн байгууллагаас 12 ажилтан, боловсролын байгууллагын 6 багш, нийт 38 төлөөлөгч хамрагдаж, кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг хөгжүүлэх нөхцөл боломжийн талаар туршлага солилцсон.</p> <p>3. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх төслийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 22-оос 11 дүгээр сарын 1-ний хооронд Индонез улсад зохион байгуулагдах кибер аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр боловсруулах, гуравдагч орны сургалтад Шинжлэх ухаан, технологийн их сургуулын 4 багшийг хамруулсан. Нийт 10 багшийг сургалтад хамруулсан. Сургалтад хамрагдсан хүний тоо нийт-82.</p>
		Олон нийтэд мэдлэг олгох арга хэмжээг зохион байгуулсан тоо	0	2	-	<p>1. Монгол банк, Цагдаагийн ерөнхий газар, Монголын банкны холбоотой хамтран цахим орчинд үйлдэгдэж байгаа санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор "Unsend" буюу "Бүү шилжүүл" уриатай 14 хоногийн аяныг зохион байгуулав.</p> <p>"Unsend" буюу "Бүү шилжүүл" аяныг дүгнэж, цаашид энэ чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил харилцаа холбооны яам, Монгол банк, Улсын ерөнхий прокурор, Монгол банкны холбоо хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж, гарын үсэг зурах арга</p>

						хэмжээг 2022 оны 12 сарын 12-ны өдөр зохион байгуулсан.	
	4.1.8. Хүний хувийн мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл, биометрик болон генетик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлыг хангах нөхцөл шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангуулах	Технологийн аюулгүй байдлыг хангах нөхцөл шаардлагыг тодорхойлсон баримт бичиг боловсруулсан байна.	0	1	-	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 13 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд европын холбооны хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай баримт бичгүүдийг судалж, журмын төслийн эхний хувилбарыг боловсруулаад байна. Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавих шаардлага, анхааруулгад тусгах мэдээллийн журмын төслийг боловсруулж, 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авч журмын төсөлд тусгасан. Европын холбооны хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой баримт бичгүүдийг судалж, хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага, үнэлгээ хийх зааврын төслийг боловсруулсан. Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд нарын хамтарсан 2022 оны А/38, А/74 дүгээр тушаалаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хувийн мэдээллээ хамгаалах талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтын модуль боловсруулах, сургалт зохион байгуулах, цахим орчинд хүний эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.	100%
	4.1.9. Кибер аюулгүй байдлын талаар иргэд, хувийн хэвшил рүү чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	2	-	1. Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг /USAID/-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй олон нийтийн мэдээллийн аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилго бүхий "Миний Минийх" компанит ажилд хамтран ажиллаж, иргэдэд өөрийн хувийн мэдээллийг хамгаалах талаарх	100%

						<p>мэдлэг ойлголт өгч нийгмийн мэдээллийн сүлжээнд байршуулан олон нийтэд хүргэж байна.</p> <p>2. "Кибер аюулгүй байдал, халдлагад үзүүлэх хариу арга хэмжээ"-ний талаар мэдлэг ойлголт өгөх багц сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Уг сургалтад төрийн 45 байгууллагын 136 албан хаагч, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн болон хувийн хэвшлийн 166 байгууллагын 427 инженер техникийн ажилтан, нийт 563 ажилтан, албан хаагчдыг хамруулан кибер халдлага, зөрчилд хариу үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэхэд бэлтгэх, байгууллагын тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх талаарх мэдээлэл өгсөн.</p>	
<p>Үндсэн чиг үүрэг 5: Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар яамны бүтэц цомхон, чадварлаг сайдын эрхлэх ажлын хүрээний үйл ажиллагаанд Засгийн газраас төсөвлөсөн хөрөнгө, нөөцийг хуваарилан зохицуулах, хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, байгууллагын санхүүг эрхлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх</p>							
5.1.Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах	5.1.1.Төрийн захиргаа, хүний нөөцийн манлайллыг хангах, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Улсын Их хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хяналт тавьж тайлагнах	Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна. Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хагас жил тутам тайлагнасан байна.	2022-2024 оны яамны стратеги төлөвлөгөө ний төсөл боловсруулсан.	Жилд 1 удаа, нийт 3 удаагийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна. Жилд 2 буюу нийт 6 удаа тайлагнасан байна.		2022 оны Монгол Улсын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 12 удаа сар бүр цахим системээр, 2022 оны 07 дугаар сарын 07-ны 01/1171 дүгээр албан бичгээр, 2022 оны жилийн эцсийн тайлан 2023 оны 01 дүгээр сарын 27-ны 01/200 дугаар албан бичгээр 2 удаа албан бичгээр тус тус тайлагнасан.	90%
	5.1.2.Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн	Бүртгэлд авсан өргөдөл, гомдол шийдвэрлэсэн хувь	0	Бүртгэлд авсан өргөдөл, гомдлын 80	-	Нийт 80 өргөдөл, санал хүсэлт бичгээр ирсэн ба үүнээс 22 нь иргэдээс, 58 нь тус яамны албан хаагчдаас ирсэн байна.	100%

	<p>авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих</p>			<p>хувийг шийдвэрлэсэн байна.</p>		<p>Мөн "Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-өөр дамжуулан 322 санал хүсэлт, гомдол ирүүлснийг холбогдох албан хаагч болон байгууллагуудтай холбогдон хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.</p>	
	<p>5.1.3.Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар байгууллагын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны бодлого боловсруулан төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах</p>	<p>Албан хаагчийн судалгааг шинэчилсэн байна. Сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулсан байна. Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо</p>	<p>Хүний нөөцийн удирдлага мэдээллийн цахим системд албан хаагчийн судалгаа хийсэн.</p> <p>Сургалтын төлөвлөгөөг жил бүр батална.</p> <p>Сургалтын төлөвлөгөө боловсруулсан.</p>	<p>Нийгмийн баталгааны хөтөлбөрийг 2 жил тутамд шинэчилсэн байна.</p> <p>Сургалтын төлөвлөгөөг жил бүрийн 1-р улиралд батлуулж, 2, 3-р улиралд хэрэгжилтийг хангуулж, 4-р улиралд тайланг гаргасан байна. Жилд 70 албан хаагч, 3 жилд нийт 210 албан хаагчийг сургалтад хамруулсан байна.</p>		<p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарын бичгийн даргын 2022 оны А/129 дугаар тушаалаар баталсан.</p> <p>Сангийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Төсөв, санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл"-ийн хүрээнд сургалт, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийн шилжилт, шинэчлэлтэй холбоотой сургалтуудад Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн албан хаагчдыг хамруулав. Архивын ерөнхий газраас зохион байгуулдаг архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад тус яамны архив-бичиг хэргийн мэргэжилтнээр ажиллаж байгаа 2 албан хаагчийг хамруулсан.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн суурь мэдлэг олгох худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх эрх олгох сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулж байгаа улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх "Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт"-д 1 албан хаагч, "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт"-д 2 албан хаагч, "Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт"-д 2 албан хаагч, "Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт"-д 3 албан хаагч, "Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт"-д 3 албан хаагч, Удирдлагын академийн</p>	<p>100%</p>

						Мэргэшил дээшлүүлэх институтээс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсан дараах чиглүүлэх цахим болон танхим хосолсон чиглүүлэх сургалтад 102 албан хаагчийг хамруулсан.	
	5.1.4.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, авлигын эсрэг яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах	-Мэдүүлэг гаргасан албан хаагчийн тоо -ХАСУМ, ХАСХОМ-ын тоо -Төлөвлөгөө батлагдсан байна. -АТГ-д тайлан хүргүүлсэн байна. -АТГ-н сургалтад хамруулсан албан хаагчдын тоо	Тухай бүр	-Авлигын эсрэг яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, холбогдох газарт тайлагнасан байна. -Нийт албан хаагчдыг ХАСХОМ, ХАСУМ-ыг хуулийн дагуу бүрдүүлэлтийг хийлгэж, Авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалтад хамруулсан байна.	-	Цахим хөгжил, харилцаа холбооны яам шинээр байгуулагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн аргачлалын дагуу авлигын эсрэг төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мэдээллийн самбарт болон байгууллагын цахим хуудсанд байрлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-д тус яамны үндсэн болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний биелэлтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн цахим систем http://khutulbur.iaac.mn -д хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан. Төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны 12 сард Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдсан.	100%
5.2.Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх	5.2.1.Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр, бусад байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, цахим хөгжил, харилцаа холбоо,	Саналын тоо	Тухай бүр	Улсын Их хурал, Засгийн газраас санал авахаар ирүүлсэн хууль, журам, хэм хэмжээний актын төсөлд хууль эрх зүйн	-	Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд батлах нийтээр дагаж мөрдөх 19 хэм хэмжээний акт /8 журам, 3 шаардлага, 4 аргачлал, 4 жагсаалт/-ын төслийг боловсруулж, батлуулах болон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. Мөн 339 албан бичгийг хянаж шийдвэрлэсэнээс	100%

	мэдээллийн технологийн талаарх хууль, тогтоомжийг боловсронгуй болгоход хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх			туслалцаа /санал/ үзүүлсэн байна.		Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад яамдаас боловсруулсан 56 хуулийн төсөл, 12 Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 145 Засгийн газрын тогтоолын төсөлд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын саналыг хүргүүлсэн.	
5.3.Санхүү хөрөнгө оруулалт	5.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах	Төлөвлөгөөний тоо Тайлангийн тоо	Төлөвлөгөөг жилд 1 удаа Тайланг сар бүр	Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг жилд нэг удаа төлөвлөсөн байна (нийт 3 удаа). Төсвийг төлөвлөсөн зориулалтын дагуу зарцуулж сар бүр тайлагнасан байна. (нийт 36 удаа)	-	-2023 онд урсгал 44,1 тэрбум, хөрөнгө оруулалтад он дамжих 3, шинэ 8 төсөл арга хэмжээнд 36,5 тэрбум нийт 80,6 тэрбум төгрөгийн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцын 2023 оны төсвийн төслийг боловсруулсан. Мөн 2023 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжийн дагуу холбогдох маягтуудыг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу Сангийн яам болон Улсын Их Хуралд 01/1366 дугаар албан бичгээр 2022 оны 8 сарын 12-ны өдөр хүргүүлсэн. -2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын 2023 оны төсөв батлагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад 64.6 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцын урсгал зардлын төсөвт 30.06 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсөвт 6.38 тэрбум төгрөг батлагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцын нийт төсвийн гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 26.9 тэрбум төгрөг буюу 76%-ийн гүйцэтгэлтэй байна. -Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-д Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад тодотголоор 11 төсөл, арга хэмжээнд нийт 6.38 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. 3 төсөл арга хэмжээ эрх шилжсэн. 2022 онд	100%

						хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 5.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	
	5.3.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал, төрийн өмчийн бүртгэлд хяналт тавих, тайлагнах	Тайлангийн тоо	Тухай бүр	-		Цахим хөгжил, харилцаа холбооны яамны урсгал зардлын санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалтын тайланг гаргаж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу боловсруулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн аудитын хяналт шалгалт 04 сарын 5-аас 25-ны өдрүүдэд хийгдсэн. Харилцаа холбоо мэдээлэл технологийн газар, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүгийн тайлангийн хяналт шалгалттай холбогдох тайлан мэдээ, баримт бичиг, тулган баталгаажуулж судалгааг боловсруулж, мөн тайлбар мэдээллийг аудитад хүргүүлсэн. -Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай" 115 дугаар тогтоолоор Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын балансад бүртгэлтэй 2023 ширхэг, нийт 1,816,990,747.47 төгрөгийн өртөгтэй 463,779,971.94 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгө нийт 43,548,172,862.29 төгрөгийн өртөг бүхий эргэлтийн хөрөнгийг тус тус Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12 нэр төрлийн 108 ширхэг 51,368,310 төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, нийт үнийг 13,700,000 төгрөгөөр шинэчлэн тогтоож, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд балансаас балансад шилжүүлэх тогтоол гарсан.	100%

	5.3.3.Харьяа төсөвт нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх	Хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулсан байна.	Тухай бүр	-	-	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлуудын хүрээний харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийг иргэн, олон нийтэд хүргэх үүрэг хүлээсэн албан хаагчдад 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Шилэн дансны тухай хуулийн хүрээнд сургалт зохион байгуулсан. -2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Салбарын харьяа 8 байгууллагын 14 санхүүгийн ажилтан нарт Сангийн яам, Үндэсний аудитын газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төлөөлөл, багш нараар Төрийн аудитын хууль тогтоомж, Засгийн газрын нэгтгэсэн тайлан бүртгэл, Төрийн өмчийн хөрөнгийн тооллого, хөдөлгөөний талаар сургалтад хамруулж, нягтлан бодогч нартай мэдээлэл солилцож, арга зүйн зөвлөгөө өгсөн. -Тайлан нэгтгүүлэх, төсөвт өөрчлөлт оруулах талаар зөвлөмж чиглэлийг "И-Монгол академи" УТҮГ, "Үндэсний дата төв" УТҮГ-ууд тухай бүрд нь хүргүүлсэн.	100%
5.4.Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	5.4.1.Салбарын олон талт болон хоёр талт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааны тасралтгүй байдлыг хангах	Салбарын гишүүнчлэл бүхий байгууллагын тоо	7	Салбарын гишүүнчлэл бүхий 7 байгууллагын хамтын үйл ажиллагааг тасралтгүй хангасан байна.	-	Мэдээлэл, харилцаа холбооны салбарын олон улсын болон бүс нутгийн 7 байгууллагаас зохион байгуулсан 26 хурал, зөвлөгөөнд харилцаа холбоо, сансар судлал, газарзүй, тандан судалгааны салбарын 28 төлөөллийг биечлэн, 34 төлөөллийг цахимаар тус тус оролцуулсан.	100%
Үндсэн чиг үүрэг 6. Салбарын стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх							
6.1 Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг салбарын болон байгууллагын түвшинд хэрэгжүүлэх	6.1.1.Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, даргын зөвлөлийн хурлаар оруулах, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан	Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн тоо -хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн зөвлөмжийн тоо	0	2 жилийн хугацаанд нийт 18 зөвлөмжийн тоо гарсан байх ба хяналт-шинжилгээ,	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны 01 дүгээр сараас 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 14 зөвлөмжийн биелэлтийн баталгаажсан тайланг Засгийн газрын Хэрэг эрлэх газар, Эдийн засаг хөгжлийн яаманд тухай бүр хүргүүлсэн. Үүнд:	100%

	<p>эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагнах</p>			<p>үнэлгээ хийсэн зөвлөмжийг холбогдох газар хэлтэст, тайланг ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн байна.</p>	<p>-Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтэд 3 удаа; -"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтэд 2 удаа; -"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн биелэлтэд 2 удаа; -"Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийн бодлогын баримт бичгийн биелэлтэд 2 удаа; -"Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичгийн биелэлтэд 2 удаа; -Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд 3 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн газар, хэлтэс тус бүрд зөвлөмж өгч, ажилласан.</p>	
	<p>6.1.2.Яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах</p>	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт зөвлөмжийн тоо</p>		<p>2 жилийн хугацаанд нийт 12 дүгнэлт зөвлөмж гарсан байх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлснээр яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн</p>	<p>Яамны 2022 оны 03 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит хийжсэн. Яам, харьяа, салбар байгууллагуудад өгсөн Үндэсний аудитын газрын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, биелэлтийг сайдын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1548 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. Харьяа, салбар байгууллагуудаас 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч, яамны газар, хэлтсүүдийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэсэн. Сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/68 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд нийцлийн хяналт шалгалт хийж, тайланг</p>	<p>100%</p>

				этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, зарцуулалт сайжирсан байна.		сайдын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/1931 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	
6.1.3.Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих	Хяналт-шалгалт хийсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо	0	Жилд 1 зөвлөмжийн тоо гарган хяналт - шинжилгээ, үнэлгээ хийсэн зөвлөмжийг холбогдох газар хэлтэст, тайланг ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн байна.	-	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/108 дугаартай "Томилолтоор ажиллуулах тухай" тушаалаар 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Ховд аймгийн Алтай, Зэрэг, Мөст Дуут, Баян-Өлгий аймгийн Алтай Цагаан-нуур, Буянт, Цэнгэл, Хөвсгөл аймгийн Их-Уул, Тариалан, Цэцэрлэг сумдад харилцаа холбооны цамхаг, Архангай аймгийн Цэнхэр, Хашаат сумдад үйлчилгээний төвийн нэгдсэн барилгын явц хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 1 зөвлөмж гарган, холбогдох газруудад хүргүүлсэн.	100%	

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд
2023 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн
01/24 дугаартай тушаалын 01 дүгээр хавсралт.

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2023 оны 1 сарын 23-ны өдөр

№2

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагаан дахь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний Стратеги төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Стратеги төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Стратеги төлөвлөгөөнд тусгасан 73 арга хэмжээний гүйцэтгэлийг 2022 оны жилийн эцсийн байдлаар яамны газар, хэлтэс тус бүр хариуцсан чиг үүргийн дагуу тайлагнаж, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа:

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн гүйцэтгэлтэй – 40 арга хэмжээ;
2. Холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч ирж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн гүйцэтгэлтэй – 5 арга хэмжээ;
3. Дээд шатны байгууллагад өргөн барьсан, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй – 10 арга хэмжээ;
4. Боловсруулалтын шатны арга хэмжээ хийгдсэн буюу 50%-ийн гүйцэтгэлтэй – 0 арга хэмжээ;
5. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30%-ийн гүйцэтгэлтэй- 14 арга хэмжээ;
6. Үр дүнгүй буюу 0%-ийн гүйцэтгэлтэй – 4 арга хэмжээ.

Дээр дурдсан арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг арифметик дунджаар тооцож үзэхэд стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 76.3 хувьтай үнэлэгдсэн бөгөөд энэхүү үнэлгээг Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг үүсгэн байгуулснаас хойших хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн болно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үзэхэд бүрэн хэрэгжсэн, тодорхой шийдвэрүүд гарч үр дүн гарч байгаа, тодорхой үр дүнд

хүрсэн арга хэмжээ нийт арга хэмжээний 75.3 хувийг эзэлж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас баталсан цахим хөгжлийг дэмжсэн багц хуулиуд болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан даган гарах нийт 37 дүрэм, журам, аргачлал батлуулахаас 20 журмыг баталсан, 13 журмын төсөлд холбогдох байгууллагуудаас санал авах шатанд байгаа, 4 журам боловсруулах шатанд байгаа нь тус яам 2022 онд дэвшүүлсэн зарим зорилтоо хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлуудыг үр дүнтэй зохион байгуулсан гэж дүгнэж байна.

Харин хэрэгжилт хангалтгүй, үр дүнг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй буюу гүйцэтгэлгүй арга хэмжээ нийт арга хэмжээний 24 орчим хувийг эзэлж байна. Санхүүжилт удаашралтай, урт хугацааны туршид хэрэгжих болон зохион байгуулалтаас шалтгаалсан тул доор дурдсан зарим заалтын хувьд хэрэгжилт хангалтгүй буюу үр дүнгүй гэж үзэж 0 хувиар үнэлсэн болно. Үүнд:

-Стратеги төлөвлөгөөний 1.1-д “Харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим засаглал, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын холбоо, инновацын бодлогыг төлөвлөх, салбарын хөгжлийн бодлого, хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах” зорилтын хүрээнд 1.1.13 дахь хэсэг “Салбарын судалгаа, шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа, хөгжүүлэлтийн ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх”-ээр төлөвлөсөн. Уг ажлын биелэлтийг ирүүлэхдээ “Монгол Улсыг хөгжүүлэх 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд “Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, инновацын кластер байгуулах ТЭЗҮ боловсруулах” төслийн танилцуулгыг, холбогдох маягтын дагуу боловсруулсан. Буянт-Ухаа нисэх буудлын байрны тодорхой хэсгийг түшиглэн, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн үйл ажиллагааг өргөжүүлж, Монголын цахиурын хөндий, мэдээлэл технологийн чөлөөт бүсийг бий болгох зорилготой “Буянт-Ухаа инновацын төв”-ийг байгуулах талаар холбогдох судалгааг хийж, ЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Мэдээлэл, холбооны өндөр технологийг хөгжүүлэх, инновацын чиглэлээр хамтран ажиллах зорилгоор олон улсын томоохон байгууллагуудтай хамтран ажиллах талаар судалж, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлон эдгээр байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг хүсэх талаар Гадаад харилцааны яаманд 2022 оны 03/2089 дугаар албан бичгээр хүсэлт илгээгээд байна” гэж тайлагнасан бөгөөд уг арга хэмжээний хүрээнд бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа гэж үзэн “0” гэж үнэлсэн.

-Мөн төлөвлөгөөний 4.1-д “Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах” зорилтын хүрээнд 4.1.3-т “Кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцооны тогтолцоог бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах” арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв байгуулагдсаны дараа кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ” гэж тайлагнасан байдлаас үзвэл уг арга хэмжээ хэрэгжээгүй гэж үзэн үнэлгээг “0” гэж үнэлсэн.

-Төлөвлөгөөний 4.1.5-д “Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавих” арга хэмжээг төлөвлөсөн ба “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, аудит хийх журам батлагдаагүйн улмаас мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийн бүртгэл хийгдэж эхлээгүй. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам батлагдаагүйн улмаас кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдийн бүртгэл хийгдээгүй байна” гэж, 4.1.6-д “Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ технологи, инновац судалгаа,

шинжилгээний үйл ажиллагааг нэмэгдүүлэх” арга хэмжээний хувьд “Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлэхээр Кибер аюулгүй байдлын үндэсний стратегид тусгасан” гэж тус тус тайлагнасан нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Мөн Хангалтгүй хэрэгжилттэй ажлуудыг эрчимжүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Стратеги төлөвлөгөөний нийт 73 арга хэмжээний хувьд зорилт тодорхой байгаа боловч, зарим арга хэмжээний хувьд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин хоорондоо уялдаагүй, хэрэгжүүлэх арга замыг ойлгомжгүй, хэт ерөнхий агуулгаар тодорхойлсноос үнэлгээ хийхэд хүндрэлтэй байсан болно. Мөн газар, хэлтсүүдээс ирүүлсэн зарим арга хэмжээний биелэлт нь зорилт, шалгуур үзүүлэлттэйгээ нийцээгүй байдлаар тайлагнасан дутагдлууд байна. Түүнчлэн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон яамны нэгжүүд хоорондоо уялдаа холбоогүй ажилласан буюу зохион байгуулалтгүйгээс хэрэгжилт хангалтгүй буюу 0-30 хүртэлх хувиар үнэлгээ хийгдлээ.

Иймд цаашид төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа ойлгомжтой, тодорхой гаргаж хэвшихийг анхаарах шаардлагатай болохыг дурдан дараах зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, яамны бодлогын газруудад:

1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний биелэлтийг хариуцан гаргах үүргийг газар, хэлтсийн нэг ажилтанд хариуцуулах;

2.Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан байдлаар гаргаж хэвших;

3.Үр дүнд суурилсан бодит нотолгоонд тулгуурласан тайлан бичиж ирүүлэх;

4.Тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын тайлан мэдээ нэгтгэж байгаа албан хаагчид арга хэмжээний биелэлтийг заасан хугацаанд шуурхай хүргүүлж хэвших;

6.2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

7.Биелэлтийг ирүүлэхдээ төлөвлөсөн арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан тодорхой, ойлгомжтой үг хэллэгээр гүйцэтгэлийг тайлагнаж хэвших;

7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг мөрдлөг болгон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудад анхаарлаа хандуулж, ажил тус бүрийн биелэлтийг ахиулахад шат дараалалтай арга хэмжээ авч ажиллана уу.

Тус яамны Төрийн захиргааны удирдлагын газарт:

1.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлантай танилцаж холбогдох баримт материалыг судлан үзэх, үнэлгээ хийх, сайдын зөвлөлийн хуралд танилцуулах зэрэг боломжит хугацааг анхаарч тайлагнаж хэвших;

2.Тайлан нэгтгэлийг хариуцаж байгаа албан хаагчид сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, яамны нэгжийн тайлангийн удирдлагаар баталгаажуулсан

хувийг нэгтгэн авч эцсийн байдлаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт өгч хэвших;

3.Төлөвлөгөөний зорилт, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан гүйцэтгэлийн тайланг өгч хэвших;

4.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх, үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хэрхэн сайжруулах, тайлагнах талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллах шаардлагатай байна.